



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр, Бага тойруу-15,  
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0066  
Утас: 7575-7807, Факс: (976) 7575-7809  
E-mail: contact@ub-procurement.mn  
http://www.ub-procurement.mn

2020. 04. 14 № 02/583  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулгад хариу хүргүүлэх тухай

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх сургууль, цэцэрлэгийн барилгын их засварын ажил НХААГ-20/0052 дугаартай төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигтэй холбоотой тендерт оролцогчдоос ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлэв.

Мөн багц 12, 16 дугаар төсөл, арга хэмжээний зураг төсвийн үнийг дараах байдлаар залруулж байна.

Багцын дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Зураг төсвийн үнэ /төгрөг/
Багц-12	119 дүгээр сургуулийн засвар /НД, 2 дугаар хороо/	2,400,000
Багц-16	119 дүгээр цэцэрлэгийн засвар /СХД, 16 дугаар хороо/	800,000

ДАРГА



Э.БОЛОРМАА



НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ГАЗАР ОНОЛААГУГ

Бодь цамхаг, Ц.Жигжиджавын гудамж-7/1,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-003  
Утас: 31-16-30, 31-16-32, 32-42-49  
Факс: (976-11) 32-46-23, <http://www.invest.ub.gov.mn>

2020.04.13

№ 3/1231

танай

-ны №

-г


НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН  
АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

Танай газрын ирүүлсэн 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 02/526 дугаартай албан бичигтэй танилцлаа.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/162 дугаар захирамжаар батлагдсан сургууль, цэцэрлэгийн засварын ажлуудын зураг төсөв нь эрх бүхий байгууллага болох Барилгын хөгжлийн төв, орон тооны бус экспертүүдээр хянагдан магадлалын нэгтгэсэн дүгнэлтээр баталгаажсан.

Иймд магадлал хийгдсэн ажлын зураг төсөвт тусгагдсан ажлын тоо хэмжээ, материал өөрчлөгдөхгүй болно.

ДАРГА



Б.МӨНХБАТ

31506000115



# “АЗ БОЛД КОНСТРАКШН” ХХК

2020 оны 04 сарын 06 өдөр

№ 20/10

Улаанбаатар

## НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

### Тодруулга авах тухай


Манай компани нь 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зарласан НХААГ/202003548 дугаартай “Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх сургууль, цэцэрлэгийн барилгын их засварын ажил” тендер сонгон шалгаруулалтын сургууль цэцэрлэгийн дээврийн засварын ажилтай холбоотой зарим асуудалд тодруулга авах хүсэлтэй байна. Үүнд:

1. Дээврийн засварын ажлын зурагт PVC мембраман материал наахаар үзүүлсэн. Гэвч төсөвт тусгасанаар ажлын даалгавар болон материалын тооцоо нь энгийн хар цаасны үнээр өгөгдсөн байна. Ийнхүү ажлын зураг болон төсөв 2 хоорондоо уялдахгүй байгаа нь ажлын гүйцэтгэлд яг аль цаасыг ашиглах нь тодорхойгүй байна.
2. Дээврийн засварын ажлуудын зурагт үзүүлсэн PVC мембраан материалын зах зээлийн үнэ доод тал нь 1 м.кв нь 20000-22000 төгрөгөөр зарагдаж байгаа. Гэвч төсөвтөө 15000 төгрөг буюу энгийн хар цаасны үнэлгээгээр тооцсон байгаа зэрэг асуудлуудад тодруулга өгч бидний ажилд дэмжлэг үзүүлнэ үү

Хүндэтгэсэн

ЗАХИРАЛ

Б. ГАНЗОЛБОО



Баянмалмаг  
Каричуу Куррууян  
2020.04.06  
Баян